БАТЛАВ

ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Э.ДАВААНЯМ

2023 оны 11 дүгээр сарын 10

# НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН БИЕ ЗАСАХ БАЙГУУЛАМЖ БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР

| № | Хийгдэх ажлын нэр | Бүрдүүлэх баримт, гарах үр дүн |
|---|---|---|
| 1 | Нийтийн бие засах газар | Нийтийн эзэмшлийн талбайд бие засах байгууламж барих (зөөврийн боловсон жорлон) |
| 2 | Байршил | Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум |
| 3 | Захиалагч байгууллага | Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ |
| 4 | Ажлын тоо хэмжээ, тавигдах шаардлага | Тавигдах шаардлага<br>➢ Ариун цэврийн байгууламжийн цэвэр, бохир ус, дулааны шугам хоолойн байрлал болон угсралт нь БНбД 40-06-16 “Дотор сантехнизийн систем”-ийн шаардлагад нийцсэн байна.<br>➢ Бие засах суултуурын өрөө, гар угаах өрөөний ханыг (доторлогоог) ус чийгэнд тэсвэртэй, галд тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалаар хийсэн байна.<br>➢ Дотор талын ус, цахилгаан, дулааны шугамыг далд хийцээр хийнэ.<br>➢ Ус зайлуулах хоолойн гарах шугам хоолойг PVC материалаар хийнэ.<br>➢ Цэвэр бохирыг бүрэн шийдвэрлэх<br>➢ Хаалганы цоож бат бэх, гадна, дотроосоо онгойдог байна.<br>➢ Ариун цэврийн байгууламжийн барилгын гадна талын хаягийг босоо хэлбэрээр, нүдэнд шууд харагдах газар угсарч байрлуулна.<br>➢ Суултуурын тусгаарлах хаалт нь бат бэх, ус чийг, ялзрал элэгдлийн хамгаалалттай, цэвэрлэхэд хялбар материалаар хийгдсэн байна. Өргөн нь 0.45 м-ээс, өндөр нь 0.8 м-ээс багагүй байна. Тусгаарлах хавтанд тавиур, тавцан угсрах, тодорхой даац авах боломжтой байна.<br>➢ Эрэгтэй, эмэгтэй тусдаа ариун цэврийн өрөөний гар угаах угаалтуурын тоог MNS 6392:2013 “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” /4.2 Барилга байгууламжийн эрүүл ахуйн шаардлага MNS 4236:2003/-ын дагуу төлөвлөнө.<br>**Ажлын тоо хэмжээ**<br>Нийтийн бие засах боловсон жорон нь дотор хэсэгт техникийн өрөө болон бие засах өрөө буюу үндсэн байгууламж гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. (Тасалгаатай)<br><u>Байгууламуийн гадна хэсэг:</u> |

| | | |
|---|---|---|
| | | Сууж бие засах зориулалттай байгууламж нь өвлийн улиралд ашиглаж болохуйц дулаалга, доторлоготой (хана, тааз, шал гэх мэт) урт 6 м, өргөн 2.4 м-ээс багагүй хэмжээтэй тохижуулсан 20 тн-ын контейнер байна.<br>Контейнерийн гадаргуу ус, чийгэнд тэсвэртэй төмрийн зориулалтын будгаар будах бөгөөд цагаан саарал өнгөтэй, хүрээг цагаан өнгөөр будна.<br>*Цонх:* Битүүмжлэл сайтай 0.5 м x 0.8 м хэмжээтэй вакум цонх 2 ширхэг<br>*Хаалга:* Дулаалгатай, бат бэх 0.96 м x 2.05 м хэмжээтэй хаалга байна.<br>*Шал:* Хөөсөн хавтангаар дулаалж, модон шалтай (захиалагчтай зөвшилцөх) байна.<br>*Хана, тааз:* Дулаалгатай доторлогоо хийнэ. (Материалыг захиалагчтай зөвшилцөх)<br>Дотор хэсэг:<br>Байгууламжийн дотор зохион байгуулалт нь техникийн болон бие засах өрөө буюу үндсэн байгууламж гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.<br>1. Бие засах үндсэн байгууламж хэсэгт дараах бүрдэл орно. Үүнд:<br>1.1 Суултуур болон түүний дагалдах тоног төхөөрөмж нь бүрэн бүтэн, эвдрэл гэмтэлгүй байх бөгөөд 4 суултуур (эрэгтэй, эмэгтэй) байна.<br>1.2 Байгууламж дотор 4 тасалгаатай байх бөгөөд тасалгааг бат бэх хавтангаар хийж, бие засах өрөөний хаалганы нээгдэх хэмжээ 0.6 м x 2.0 м, кабин хэмжээ нь 0.85 м x 1.50 м-ээс багагүй байна.<br>2. Техникийн өрөө<br>2.1 Нөөцийн зориулалтын сав 1 тн багтаамжтай байх<br>2.2 Халуун, хүйтэн усны 80 Вт-ын бойлер байрлуулах<br>2.3 Сантехникийн шугам хоолойг PVC материалаар хийнэ. Диаметр нь 160 мм-ээс багагүй байна.<br>2.4 Насос суурилуулахад (550 Вт-аас багагүй)<br>Нэмэлт тоноглол:<br>1. Угаалтуур 2 ширхэг<br>2. Розетик 4 ширхэг (техникийн өрөөнд-1, бусад-3)<br>3. Бүх цахилгаан холболтыг бүрэн шийдэх<br>4. Унтраалга 3 ширхэг (техникийн өрөөнд-1, бусад-3)<br>5. Гэрэл 4 ширхэг (техникийн өрөөнд-1, бусад-3)<br>6. Цаас болон саван тогтоогч тус бүр 2 ширхэг<br>7. Толь 2 ширхэг |
| 5 | Хийж хүлээлгэн өгөх хугацаа | Тус ажлыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөрт багтаан хийж дуусгаж, хүлээлгэн өгнө. |
| 6 | Багц ажлын үнэ | 2 ш нийтийн эзэмшлийн бие засах байгууламжийг 50,000,000 (тавин сая) төгрөгт (хийж гүйцэтгэх, ажиллах хүчний зардал зэрэг багтсан болно.) |

| | | |
|---|---|---|
| 7 | Гүйцэтгэгч байгууллагад тавигдах шаардлага | ➢ Чанартай хийж гүйцэтгэн 14 хоногт багтаан нийлүүлэх<br>➢ Баталгаа 1 жил байх бөгөөд гүйцэтгэгч эвдрэл гэмтлийг өөрийн хөрөнгөөр засварлах<br>➢ Ижил төстэй ажил хийж байсан туршлагатай байх |

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Д.АЛТАЙ

БОЛОВСРУУЛСАН:
ЗДТГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ОРГИЛМАА